

Хужирт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны
санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн тухай

Өвөрхангай аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны дотоод аудитын төлөвлөгөө болон Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан 29/01 тоот удирдамжийн дагуу Өвөрхангай аймгийн Хужирт сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

1.Аудитын зорилго:

Сумдын ЗДТГазрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа иж бүрэн, үнэн зөв, шударгаар илэрхийлэгдсэн эсэх, байгууллагын санхүүгийн тайлагналын системд үр нөлөөтэй дотоод хяналтууд хэрэгждэг эсэх, санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд дотоод аудит хийж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлтэй, дотоод хяналт сул хэрэгжиж буй асуудлыг тодорхойлж, холбогдох заавар зөвлөмжөөр хангах.

2.Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт:

Энэ удаагийн дотоод аудитыг зөвхөн санхүүгийн үйл ажиллагаанд чиглүүлэхийг зорьсон, мөн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цаг хугацаанд аудитыг багтааж, үр дүнг тайлагнах шаардлагатай тул дээр дурдсан байгууллагын засаглалын бүтэц, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг бүхэлд нь авч үзэхгүй боловч эдгээрийн зөвхөн санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох хэсгийг хамруулна. Мөн Төрийн аудитын газраас санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийгдэх тул санхүүгийн тайлагналд аудит хийхгүй.

Илэрсэн асуудлууд	Өгсөн зөвлөмжүүд
1.Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэггүй.	1. Эрсдэлийн удирдлагын бодлого, журамтай болох; 2. Байгууллагын ажилтан, албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгөх; 3. Жил бүр байгууллагын үйл ажиллагаа, дотоод гадаад хүчин зүйлс болон санхүүгийн зорилтуудад учрах эрсдэлийг шинэчлэн тодорхойлж, тохиолдох магадлал учруулах үр дагавраар нь үнэлэх, албажуулах; 4. Сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэлийг үнэлэх; 5. Тухайн эрсдэлийг бууруулах, хүлээн зөвшөөрсөн түвшинд хүртэл удирдах байдлаар төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах; 6. Удирдлагыг эрсдэлийн удирдлагын мэдээллээр хангах; 7. Байгууллагын эрсдэлийн түвшинг үнэлэн шатлал ахиулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
2. Дотоод хяналтын нэгж хяналтыг ор нэр төдий хийдэг.	1. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд дотоод хяналтын нэгжийн ажлыг үнэлэн, биелэлтийг тооцож үр дүнд суурилсан

	<p>урамшууллыг хууль тогтоомжид нийцүүлэн олгох асуудлыг тусгаж өгөх;</p> <p>2. Дотоод хяналтын нэгжийн албан хаагчийг холбогдох мэргэшүүлэх байгууллагын сургалтад хамруулж мэргэшүүлэх;</p> <p>3. Дотоод хяналтын нэгжийн жилийн төлөвлөгөөг эрсдэлд суурилан төлөвлөх;</p> <p>4. Дотоод хяналтын зураглалтай болох, түүнийг хамт олноороо мөрддөг байх;</p>
3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй.	<p>1.Боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мэргэжлийн байгууллагуудаас заавар, зөвлөгөө, сургалт авах;</p> <p>2. Өгсөн зөвлөмж чиглэлийн дагуу өөрчлөлтийг оруулж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталгаажуулан, мөрдөж ажиллах;</p>
4. Ээлжийн амралтын мэдэгдлийг буруу бичдэг, ээлжийн амралтын хоногийг буруу тооцож, цалин ээлжийн амралтын цалинг давхардуулсан, цагийн балансыг дутуу гаргадаг.	<p>1.Цалин хөлс, төсөв хөрөнгөтэй холбоотой шийдвэрийг гаргахдаа хууль тогтоомжийг үндэслэхэд эргэлзээтэй асуудал гарахад мэргэжлийн байгууллагуудаас заавар зөвлөгөө авч ажиллах;</p> <p>2. Албан хаагч бүрээр ээлжийн амралтын мэдэгдлийг бичихдээ хэдий хугацаанд ногдох амралтаа авч байгааг үнэн зөв бичиж, нэг хувийг ажилтанд, нэг хувийг хүний нөөцөд, нэг хувийг санхүүгийн баримтад хавсарган, цалин, ээлжийн амралтын цалинг илүү, дутуу олгохгүй байх;</p> <p>3. Ажлын цаг ашиглалтын бүртгэлийг албан хаагч бүрээр хянан, ажлын цагийн тооцоо, цагийн балансыг хянан баталгаажуулсаны дараа цалинг бодож хэвших;</p>
5. Анхан шатны баримтгүйгээр шатахууныг зарлагдсан шатахууны тайланд тусгаагүй, захирамж тушаал шийдвэрээр хөрөнгө зарцуулахдаа худалдан авсан бараа материалыг орлогод авч, бараа материалын тайланд тусгаагүй шууд зарлагдсан, захирамж тушаал шийдвэрээр арга хэмжээнд хөрөнгө зарцуулсныг нотлох баримт байхгүй	<p>1. Түлш шатах тослох материалын тайланд орлогыг бүрэн авч, шатахууны шаардах хуудас, жолоочийн замын тооцооны хуудсыг бүрэн хавсаргаж хэвших, үүнд нягтлан бодогч хяналтыг тогтмол тавьж ажиллах;</p> <p>2. Няравын гаргасан бараа материалын тайланд орлого бүрэн авч, зарцуулалтыг хийж байгаа эсэхэд нягтлан бодогч хяналтыг ,тогтмол тавьж, шалгаж хүлээн авч, баталгаажуулж байх;</p> <p>3. Бараа материалын тайланг дотоод хяналт шалгалтын нэгжээр хянуулан, гарсан зөрчил дутагдлыг арилган ажиллах;</p> <p>4. Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил, гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй байх, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийг мөрдөж ажиллах;</p>
6. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан.	<p>1. Төсвийн захирагч төсвийг батлагдсан төсвийн хүрээнд, зориулалтын дагуу зарцуулж байх;</p> <p>2. Төсвийн хөрөнгөөс зохих зөвшөөрөлгүйгээр зориулалт бусаар зарцуулж байгааг таслан зогсоох;</p> <p>3. Анхан шатны баримтын бүрдэл, түүний агуулга, хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг төсвийн шууд захирагч, төрийн сан, санхүүгийн албаны дарга нар тогтмол, чанартай хийж ажиллах;</p> <p>4. Авлигатай тэмцэх газраас өгөгдсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах;</p> <p>5.Мэргэжлийн байгууллагуудаас заавар, зөвлөгөөг тогтмол авч ажиллах;</p>

Цалин, ээлжийн амралтын цалинг давхардуулсан 764,647 (долоон зуун жаран дөрвөн мянга зургаан зуун дөчин долоо) төгрөг илүү олгосныг төлүүлэхээр улсын ахлах байцаагчийн акт тогтоон, түлш шатах тослох материалын тайланд 746,776 (долоон зуун дөчин зургаан мянга долоон зуун далан зургаа) төгрөгийн шатахууны шаардах хуудас, жолоочийн замын тооцооны хуудсыг бүрэн хавсаргах,

захирамж, тушаал шийдвэрээр зарцуулсан 24,702,576 (хорин дөрвөн сая долоон зуун хоёр мянга таван зуун далан зургаа) анхан шатны нотлох баримтуудыг бүрдүүлэн, санхүүгийн баримтад хавсаргахыг үүрэг болгон улсын ахлах байцаагчийн 3 заалт бүхий албан шаардлага өглөө.